



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 23 -ны өдөр

Дугаар A/13

Эрдэнэт

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11дүгээр зүйлийн 11.1, 11.8 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Хүн амыг нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд сууринлан урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгт хамруулах тухай” А/420 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ :

1. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоог зохион байгуулах бэлтгэл хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, бэлтгэл ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоог хийх бэлтгэл ажлыг бүрэн хангаж, шаардагдах төсөв, хөрөнгийн тооцооллыг гаргаж шийдвэрлүүлэн ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ажлын хэсгийн дарга / П.Хишгээ/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 2 дүгээр сарын
21.-ний өдрийн 11 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5043446 2026030036

ХҮН АМЫН НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД ҮНДЭСЛЭН УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ, ОНОШИЛГООГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

- П.Хишгээ Эх, хүүхдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

- О.Батцэнгэл /ЗДТГ-ын НБХ-ийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/
- Г.Энхжаргал /ЭМГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /
- Б.Уртнасан /ЭМГ-ын Эмнэлгийн тусlamж үйлчилгээ, чанар хариуцсан мэргэжилтэн /
- А.Хонгорзул /ЭМГ-ын ХБӨ-ний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн /
- Θ.Наранзаяа /ЭМГ-ын ЭМБМСС хариуцсан мэргэжилтэн /
- Х.Оюун-Эрдэнэ /ЭМГ-ын Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн /
- Г.Оюунтөгс /ЭМГ-ын Оношилгоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтэн /
- Баян-Өндөр сумын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/
- Алтанбек /Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга/
- Эрдэнтуяа /Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн тасгийн эрхлэгч /
- Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар
- Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн дарга
- Ж.Ганчимэг /Эрдэнэт сувилал цогцолборын ерөнхий эмч/
- /Баян-Өндөр- мед Нэгдсэн эмнэлгийн дарга /
- Гүнчинсүрэн /Хувийн хэвшлийн “Чандмань” холбооны тэргүүн/
- Медипас эмнэлгийн ерөнхий эмч

Нарийн бичгийн дарга:

- ЭМГ-ын СХТҮ, АШТҮХМэргэжилтэн А.Баярхүү

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 02 дүгээр сарын
23.-ний өдрийн 11:00 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**ХҮН АМЫН НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД ҮНДЭСЛЭН УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ, ОНОШИЛГООГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр				
1	Ажлын хэсгийг хуралдуулан төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцож, салбар дундын байгууллагууд, дээд шатны удирдлагуудыг мэдээллээр хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх	7 хоногт 1 удаа	Ажлын хэсэг	Засаг дарга НБХэлтэс БӨ сумын ЗДТГ БСГ ГБХЗХГ
2	Хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо хийх сургалт сурталчилгаа, нээлт, явцын үйл ажиллагааны зардлын төсвийн тооцоог гарган удирдлагуудад танилцуулах	03 сарын 01-нээс 03 сарын 04	Ажлын хэсэг	Засаг дарга НБХэлтэс
3	Үзлэгт хамрагдсан иргэд, ЭМГ-уудын үзлэг оношилгоо хийх хүчин чадлын мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн программд бүртгэх ажлын бэлтгэл ажлыг хангах	03 сарын 01-нээс 03 сарын 25	Х.Оюун-Эрдэнэ ЭМГ	ЭМБ-ууд
4	Иргэд, ААНБ, албан байгууллагуудад урьчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдах мэдээлэл сургалт сурталчилгааг төлөвлөгөөний дагуу үе шаттай зохион байгуулах	03 сарын 01-нээс 04 сарын 25	Ө.Наранзаяа ЭМГ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд, Төрийн байгууллагууд ААНБ-ууд
Хоёр. Үйл ажиллагааны чиглэлээр				
5.	ЭМБ-уудын урьчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо хийх чадамж, түүнд ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг нэгтгэн үнэлгээ дүгнэлт гаргах	02 сарын 21-нээс 03 сарын 11	Г.Оюунтөгс ЭМГ	ЭМБ-ууд
6	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн нэр төрлийн дагуу ЭМБ-уудад хуваарилах, бэлэн байдлыг хангуулах, цаг товтолоор хамруулах	02 сарын 21-нээс 04 сарын 25 хүртэл	Ажлын хэсэг	ЭМБ-ууд